



МОНГОЛ УЛСЫН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН  
ТУШААЛ

2019 оны 03 сарын 12 өдөр

Дугаар А/112

Улаанбаатар хот

Мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх  
зөвшөөрөл хүчингүй болгох тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2, Эрүүгийн хуулийн 5.7 дугаар зүйлийн 3, 15.1 дүгээр зүйлийн 3 дах хэсэг, Нийслэлийн Хан-Уул дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2018 оны 1 дүгээр сарын 26-ны өдрийн 36 дугаартай шийтгэх тогтоол, Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2019 оны 2 дугаар сарын 18-ны өдрийн 3/4180 тоот албан бичгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Хүний их эмч Даваасамбуугийн Оюун-Эрдэнийн ИЭ0017416 сери, 0017416 дугаартай эмчлэх үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг 2019 оны 3 дугаар сарын 27-ны өдрөөс нэг жил зургаан сарын хугацаагаар хүчингүй болгосугай.


2. Д.Оюун-Эрдэнийн эмчлэх үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг хүчингүй болгосонтой холбогдуулан дор дурдсан арга хэмжээг авч ажиллахыг Эрүүл мэндийн хөгжлийн төв /Д.Ганцэцэг/-д үүрэг болгосугай:

2.1 Эмчлэх үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг нэг жил зургаан сарын хугацаагаар хүчингүй болгосон тухай мэдээллийг эрүүл мэндийн ажилтны нэгдсэн санд бүртгэж, Эрүүл мэндийн хөгжлийн төвийн цахим хуудсанд байршуулан нийтэд мэдээлэх;

2.2 Эмчлэх үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлөөр ажиллах эрх үүстэл буюу 2020 оны 5 дугаар сарын 28-ны өдөр хүртэл мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн шалгалтад бүртгэж, оруулахгүй байх;

2.3 Эмчлэх үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл хүчингүй болгосон талаар тус яамны дэргэдэх Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хяналтын хороо /Д.Цэрэндагва/, Хүүхэд судлалын мэргэжлийн салбар зөвлөл /Б.Баясгалантай/, Нийслэлийн Эрүүл мэндийн газар /Л.Төмөрбаатар/, Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар /Р.Энхтайван/-т албан бичгээр тус тус мэдэгдэх.

3. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын газрын дарга, Эмнэлгийн мэргэжилтний зөвшөөрлийн зөвлөлийн дарга /Б.Цогтбаатар/-д даалгасугай.



САЙД

Д.САРАНГЭРЭЛ

080486